

**ЖАРГАЛАНТ СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2025.12....

Жаргалант

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлийг тодорхойлоход нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хурлын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.							
1	Зорилт 1: Хурлын байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах						
1.1	Жаргалант сумын ИТХ-ын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг хангах	-	Стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байх	2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг хангасан.	Стратеги төлөвлөгөөг батлуулж тайлант жилийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Жаргалант сумын ИТХ-ын 2025-2028 оны 3 зорилго, 12 зорилт, үндсэн чиг үүргийн 19, дэд чиг үүргийн 51 хэрэгжүүлэх хуулийн заалт, арга хэмжээ бүхий стратеги төлөвлөгөөг боловсруулан ИТХ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90
1.2	Сумын ИТХ-ын Хуралдаан болон Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, хэлэлцэх асуудлуудын холбогдох материалыг урьдчилан хүргэх, тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг албажуулах	Батлагдсан төсөв	Хурлын хуралдааны тоогоор	Сумын ИТХ нь 2024 онд нийт 10 удаа хуралдаж асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Сумын ИТХ-ын Зөвлөлийн Хурал 2 удаа хуралдан 18 асуудлыг хэлэлцсэн.	ИТХ-ын Зөвлөлийн Хурал 4-өөс доошгүй, ИТХ-ын хуралдаан 7-с доошгүй удаа хуралдаж холбогдох материал, хурлын тэмдэглэл хугацаандаа албажиж гарсан байна.	Сумын ИТХ нь 2025 оны жилийн эцсийн байдлаар ээлжит 4, ээлжит бус 3, нийт 7 удаа хуралдаж 36 асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж холбогдох тогтоол, шийдвэрүүд гаргалаа. Сумын ИТХ-ын Зөвлөл 3 удаа хуралдан 29 асуудлыг хэлэлцэн хэлэлцэн бэлтгэлийн хангуулж, нэгдсэн хуралдаанд оруулан шийдвэрлүүлсэн ба хороодод ажлын чиглэлүүд өгсөн. Хурлын хуралдаанаар орох хэлэлцэх асуудлуудын материалуудыг холбогдох байгууллагуудаас хүлээн авч хянаад ИТХ-ын төлөөлөгчдөд хугацаанд нь цаасаар болон файлаар хүргүүлээ. Хуралдаануудын бэлтгэл ажлыг ханган	100

						ажилласан ба хуралдаануудын тэмдэглэлийг хөтлөн, нийт гарсан 36 тогтоол, шийдвэрүүдийг албажуулсан.	
1.3	Хурлын болон Зөвлөл, Хороодын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгөөг батлуулах, нутгийн удирдлагын байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах	-	Хуралдаан уудаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлуулж, холбогдох материалыг тухай бүр хүргүүлсэн байх	Сумын ИТХ-ын 2024 онд хийсэн ажлын тайлан хангалттай сайн хэмээн дүгнэгдсэн.	Хурлын болон Хороодын 2025 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилт хангагдсан байна.	Хурлын болон Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, холбогдох материалыг тухай бүрт хүргүүлсэн. Зөвлөлөөс хороодын ажиллах чиглэл болон уялдаа холбоог ханган ажилласан. Хороод хуралдан жилийн ажлыг төлөвлөгөөгөө гарган хороодын дарга нар батлан хэрэгжүүлж байна. Нутгийн удирдлагын байгууллагаас ирүүлсэн хэлэлцэх асуудал болон цаг үеийн асуудлаар хурлаар хэлэлцүүлэхээр оруулж байгаа асуудлын төлөвлөгөөг тухай бүрт ИТХ-ын даргад танилцуулж захирамжаар баталгаажуулан ажиллаж байна.	100
1.4	Төлөөлөгч, Хороодын үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлж, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, туслалцаа үзүүлэх	Батлагдсан төсөв	Арга зүйн зөвлөгөө өгсөн, мэдээллээр хангах	Сумын ИТХ-ын дэргэдэх хороод жилийн ажлынхаа төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөт хяналт шалгалтаар ажилласан.	Хороод, Төлөөлөгч нарыг шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүр хангаж, Төлөөлөгч болон Хороодын ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	ИТХ-ын ажлын алба нь төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд болон хороодын үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөөг өгч үйл ажиллагааны удирдамжийг боловсруулж ИТХ-ын даргаар батлуулж, ажиллах нөхцөл бололцоог ханган хамтран ажиллаж байна. Шинээр сонгогдсон 9 дүгээр бүрэн эрхийн 21 төлөөлөгч нарт Монгол улсын ЗЗНДНТУТ хууль болон бусад шаардлагатай хуулиар гарын авлага болон мэдлэг мэдээлэлээр хангаж, хороодын бүрэлдэхүүн болон хорооны ажиллах журмыг 9 дүгээр бүрэн эрхийн хурлын ээлжит II хуралдааны 02/06, 02/07 тогтоолуудаар шинэчилж батлуулан ажиллаж байна. Мөн чиг үүргийн давхцал арилгахаар нутаг дэвсгэр, хүн амын тоо, газар зүйн байршил, аж ахуй нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог,	90

						төлөөлөгчдийн тоог харгалзан тус бүр 5 гишүүнтэйгээр 4 хөгжлийн хороодыг байгуулан ажиллуулж, хороодын хариуцан ажиллах, хянан шалгах чиглэлүүдийг Хурлын даргын захирамжаар баталлаа.	
1.5	Сумын ИТХ-аас гарсан шийдвэрийг тухай бүр нь төлөөлөгчид, холбогдох албан тушаалтнуудад хүргэх	-	гарсан шийдвэрийн тоогоор	Сумын ИТХ-аас 2024 онд гаргасан 43 шийдвэрийг албажуулан тогтоол гаргаж, нийт төлөөлөгчид болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн.	2025 оны шийдвэрүүд төлөөлөгчдөд, холбогдох албан тушаалтнуудад тухай бүр түргэн шуурхай хүрсэн байх.	Сумын ИТХ-аас 2025 онд гаргасан 36 шийдвэрийг албажуулан тогтоол гаргаж, нийт төлөөлөгчид болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн.	90
1.6	Сумын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг ИТХ-ын хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлэх, 2026 оны төсвийн төслийг батлуулах	-	Тогтоолоор	Сумын 2024 оны Төсвийг хуулийн хүрээнд үр ашигтай зарцуулсан үнэлгээ авсан.	Сумын ИТХ-ын Хуралдаанаар 2025 оны төсвийн гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр биелэлтийг хэлэлцэж, 2026 оны төсвийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулна.	9 дэх бүрэн эрхийн сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн ээлжит III дугаар хуралдааны 02/31 тогтоолоор 2025 оны сумын төсвийг 24,748,108.05 мянган төгрөгөөр баталсан ба 2026 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаар сумын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцүүлж, 2026 оны төсвийг 25,584,390.48 мянган төгрөгөөр баталлаа.	100
1.7	2025 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргах	-	Тогтоолоор	2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг	2025 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг тогтоох шийдвэрийг хурлаар	Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны ээлжит II хуралдааны 02/11 дүгээр тогтоолоор 2025 онд сумын иргэдийн хэрэгцээнд зориулж ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай мод 100	100

				тогтоолоор тогтоосон.	хэлэлцүүлэн батлуулна	шоометр, түлээний мод 800 шоометр байхаар баталсан.	
1.8	Сумын хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хэлэлцэж дүгнэх, 2026 оны төлөвлөгөө батлах	-	Тогтоолоор	Сумын хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг танилцуулагдан, 2025 оны төлөвлөгөө батлагдсан.	Сумын хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 2026 оны төлөвлөгөөг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж тогтоол гарсан байна.	9 дэх бүрэн эрхийн сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит III хуралдаанаар сумын хэмжээнд газрын харилцааны талаар 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хэлэлцээд 01/11 дүгээр тогтоолоор сумын газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 86,5 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн ба сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөг мөн өдрийн ээлжит III хуралдааны 02/12 дугаар тогтоолоор баталсан.	100
1.9	Яаралтай тохиолдолд ИТХ-ын Ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулах, бэлтгэл ажлыг хангах	Батлагдсан төсөв	Хуралдааны тоогоор	2024 онд ИТХ-ын ээлжит бус хуралдаан 4 удаа зохион байгуулагдсан.	ИТХ-ын Ээлжит бус хуралдааныг 4-өөс доошгүй удаа зохион байгуулж хуралдуулна.	2025 оны жилийн эцсийн байдлаар хойшлуулашгүй яаралтай цаг үеийн асуудлаар сумын ИТХ-ын ээлжит бус 4 удаагийн хуралдааныг зарлан хуралдуулж 9 асуудлыг хэлэлцэн 7 тогтоол гарган шийдвэрлэлээ.	100
1.10	2025 онд ОНХСангийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын явцад бүрэн эрхийн дагуу хяналт хийх	-	Тайлангаар	2024 оны хөрөнгө оруулалтын жил бүрэн хэрэгжсэн.	2025 онд ОНХСангийн төсвөөр хийгдэх ажлын хэрэгжилт хангалттай хийгдсэн байна.	Жаргалант сумын 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 54 төсөл, арга хэмжээг 6.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх ба эхний хагас жилийн байдлаар тендер сонгон шалгаруулалт явагдаж дууссан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд хяналт тавих хороодын хуваарийг ИТХ-ын даргаар батлуулан мөрдөж байна. Хурлын даргын	90

						захирамжаар Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил үйлчилгээ, түүний хэрэгжилт, хадгалалт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, тэдгээртэй холбогдуулан гарсан журмуудын хэрэгжилтэд хяналт тавих, тооллого явуулах, дүгнэлт гаргах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсгийг Ж.Эрдэнэ-Очир төлөөлөгчөөр ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан ба ажлын хэсгийн тайлангийн сонсголын хуралдаанаар хөтөлбөрүүдийн биелэлт, өмчийн ашиглалт, захиран зарцуулалт, сумын байрнуудын орцны засвар, Жаргалант усын засварын талаар дутуу мэдээллүүдийг бүрэн гүйцээж сумын ИТХ-ын хуралдаанд оруулахыг даалгалаа.	
1.11	Бусад байгууллагуудын тавьсан холбогдох асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх	-	Хурлаар хэлэлцсэн асуудлын тоогоор	2024 онд ИТХ-д бусад байгууллагууд аас 35 асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсаныг хурлын хуралдаанаар оруулан хэлэлцүүлж холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гаргасан.	Байгууллагуудаас ИТХ-аар хэлэлцүүлэхээр хандсан асуудлыг тухай бүр хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.	2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар ИТХ-д бусад байгууллагуудаас 36 асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсан ба хурлын хуралдаанаар оруулан хэлэлцүүлж холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гаргасан.	100
1.12	Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг	-	Төлөвлөгөөний хэрэгжилти	2024 оны Сумын Засаг даргын үйл ажиллагааны	Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр,	Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийг ИТХ-ын 2025 оны	100

	хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт биелэлтийг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх		йн хувь хэмжээгээр	хөтөлбөр төлөвлөгөөг хэлэлцэж хэрэгжилтэд хангалттай үнэлэлт дүгнэлт өгсөн.	түүнийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-ын хуралдаанаар биелэлтийг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгнө.	12 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит III хуралдааны хуралдаанаар хэлэлцээд 2025 оны биелэлтийг 02/17 тогтоолоор 85.1 хувь буюу "Үр дүнтэй" гэж дүгнэлээ.	
1.13	Төлөөлөгчдийг тойрогтоо ажиллах бололцоогоор хангах	Батлагдсан төсөв	Зохион байгуулсан арга хэмжээгээр	2024 онд 3 багаас сонгогдсон төлөөлөгчид багийн иргэдтэйгээ уулзалтууд хийн, ЗДТГ болон ИТХ-аас зохион байгуулсан арга хэмжээнүүд дээр хамтран ажилласан.	Төлөөлөгчдийг тойрогтоо ажиллах бололцоогоор хангах	Хурлын төлөөлөгчдийг сонгогдсон багууд дээрээ ажиллах нөхцөл бололцоогоор /машин техник, шатахуун, гарын авлага материал, хууль эрх зүйн зөвлөгөө, сонгогчидтой хийх уулзалтын байр, шаардлагатай мэдээлэл г.м/ ханган ажиллаж байна. Хурал бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын явц, гүйцэтгэлтэй танилцах, багийн иргэдэд хөрөнгө оруулалтын ажлуудын талаар мэдээлэл өгөх, иргэд, сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан хүсэлт, санал, гомдлыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид өөрсдийн сонгогдсон тойрог, багуудад 2025 оны 9 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд ажиллаа. Хурлын төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, иргэдэд мэдээлэл өгөх сумын удирдлагууд, холбогдох алба,	100

						<p>мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлтэй танилцах үеэр гүйцэтгэгч ААН, компаниудын төлөөллүүд байлцлаа. Иргэд сонгогчдод мэдээлэл хүргэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Жаргалант сумаас аймгийн ИТХ болон сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчид, аймгийн төрийн байгууллагууд оролцсон “Иргэдийн оролцоо, төлөөлөгчийн манлайлал, төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөгийг аймгийн ИТХ-тай хамтран сумандаа 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай зохион байгууллаа.</p>	
1.14	<p>Хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх</p>	-	Батлагдсан хэм хэмжээний актаар	<p>Хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлж байна.</p>	<p>Шаардлагатай хэм хэмжээний актыг тухай бүр хуульд нийцүүлэн баталж Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх чиг үүргийн хүрээнд одоогийн байдлаар “Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай” тогтоол гарган хуульд нийцүүлэн баталж Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн энэ бүрэн эрхийн хүрээнд 2025 онд “Сумын 500 тонны төмс, хүнсний ногооний зоорь ажиллуулах журам”, “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-ыг тус тус баталлаа. Мөн үнийн өсөлт, цаг үеийн нөхцөл байдлын шаардлагаар “Агро үйлчилгээний техникийн үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай” болон “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-д өөрчлөлт</p>	100

						оруулах тухай тогтоолуудыг батлаад байна.	
1.15	Хурлын үйл ажиллагаа явуулахад шаардагдах дүрэм, журам, заавар удирдамжийг тухай бүр боловсруулж, эсвэл шинэчлэн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлэх	-	Баталсан дүрэм, журам зааврын тоогоор	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны журмуудыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа. Хурлын хороод өөрсдийн чиглэлээр ажиллах бүрт удирдамж боловсруулан Хурлын даргаар батлуулж байна.	Батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.	Сумын ИТХ-ын хуралдааны “Үлгэрчилсэн дэг”, Төлөөлөгчийн энгэрийн тэмдэг, үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудасны загвар, хэрэглэх үлгэрчилсэн журам, “Хорооны үйл ажиллагааны журам”, “Хурлын Ёс зүйн дүрэм”-ийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа ба одоогийн 9 дэх бүрэн эрхийн хурлаар “Хурлын анхдугаар хуралдааны дэг”, “Хурлын хуралдааны ердийн дэг”, Хороодын бүтэц, бүрэлдэхүүн болон “Хорооны ажиллах журам”-ыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. Хурлын хороод, ажлын хэсэг өөрсдийн чиглэлээр ажиллах бүрт удирдамж боловсруулан Хурлын даргаар батлуулан ажиллаж байна.	90
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Сумын ИТХ-ын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгож, түүний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх.							
2	Зорилт 2 :Хяналт шалгалт зохион байгуулах						
2.1	Сумын ИТХ-ын үндсэн чиг үүрэгт байдаг хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын удирдамж төлөвлөгөөг боловсруулж батлуулах,	Батлагдсан төсөв	Төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт шалгалтын тоогоор	2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хороодууд болон томилогдсон ажлын хэсгүүд	ИТХ-аас гарч байгаа тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Хороод болон бусад холбогдох чиглэлээр хийгдэх	Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хянан шалгах чиг үүргийг тодорхой болгох, давхардуулахгүй үүднээс хөгжлийн хороодын хариуцах чиглэлүүдийг тус бүрт гарган ИТХ-ын даргаар 2025 оны 01 дүгээр сард батлуулан хэрэгжүүлж байна. 2025 онд ИТХ-ын даргаар удирдамж батлуулан ИТХ-ын Эдийн засаг, нутгийн удирдлага,	100

	хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах			хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын ажилд төлөөлөгч нарыг өргөнөөр хамруулж байна.	хяналт шалгалтын ажлын хэсэгт төлөөлөгчид орж ажиллана.	нийгмийн хөгжлийн хороо суманд хэрэгжүүлж буй “Эрүүл Жаргалантчууд” хөтөлбөр, “Соёлыг дэмжих” дэд хөтөлбөр, багуудад хийгдэж буй зам засвар , Жаргалант болон Улаантолгой багийн халуун ус, Хог хаягдалын цэг, Улаантолгой багийн Цэцэрлэгт хүрээлэн, үерийн зурвас, уст цэгүүдийн ажлуудын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавин, гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажиллагсадтай санал солилцлоо. Дэд бүтэц, байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн хороо “Малжуулах хөтөлбөр”, “Ногоон Жаргалант хөтөлбөр”, “Жаргалантын ногоочид хөтөлбөр”-үүдтэй танилцан үнэлэлт өгч зөвлөмж, чиглэл өглөө. Хурлын даргын захирамжаар Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил үйлчилгээ, түүний хэрэгжилт, хадгалалт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, тэдгээртэй холбогдуулан гарсан журмуудын хэрэгжилтэд хяналт тавих, тооллого явуулах, дүгнэлт гаргах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсгийг Ж.Эрдэнэ-Очир төлөөлөгчөөр ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан ба ажлын хэсгийн тайлангийн сонсголын хуралдаанаар хөтөлбөрүүдийн биелэлт, өмчийн ашиглалт, захиран зарцуулалт, сумын байрнуудын орцны засвар, Жаргалант усын засварын талаар дутуу мэдээллүүдийг бүрэн гүйцээж сумын ИТХ	
--	------------------------------------	--	--	--	---	--	--

					<p>-ын хуралдаанд оруулахыг даалгалаа. Мөн Хурлын даргын захирамжаар Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-ын төсөлтэй танилцах, дүгнэлт гаргах ИТХ-ын ажлын хэсгийг Н.Хадаа төлөөлөгчөөр ахлуулан байгуулж журмын төсөлтэй танилцан, дүгнэлт гаргаж ажлын хэсэгтэй зөвшилцсөнөөр ажлын хэсэг журмыг эцэслэн боловсруулж сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна. Хурал бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын явц, гүйцэтгэлтэй танилцах чиг үүргийг хэрэгжүүлэхээр Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид өөрсдийн сонгогдсон багуудад 2025 оны 9 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд ажиллаа. Хурлын төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, иргэдэд мэдээлэл өгөх сумын удирдлагууд, холбогдох алба, мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлтэй танилцах үеэр гүйцэтгэгч ААН, компаниудын төлөөллүүд байлцлаа.</p>	
--	--	--	--	--	---	--

2.2	ИТХ-аас гаргасан нийтээр дагаж мөрдөх тогтоол шийдвэрүүдийг хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж хувийн хэрэг хөтлөх	-	Хуульд нийцсэн үндэслэлтэй байна	Сумын ИТХ-ын шийдвэрийн заалтын хэрэгжилт 2024 оны жилийн эцсээр хангалттай дүнтэй хэрэгжилттэй байна.	ИТХ-аас гаргасан нийтээр дагаж мөрдөх тогтоол шийдвэрүүдийг хуульд нийцүүлэн карт хөтлөж хяналт тавьж ажиллана.	ИТХ-аас 2023 онд нийтээр дагаж мөрдөх Улаантолгой багт байрлах халуун ус, сауны үнэ тарифыг шинэчлэн тогтоосон. Хово машин ашиглах болон төлбөрийн журам, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай тогтоолуудыг хуульд нийцүүлэн батлан мөрдүүлж байна. 2024 онд “500 тн-ын төмс, хүнсний ногооны зоорийг ашиглуулах журам”, 2025 онд “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам” батлан тогтоол шийдвэрүүдийг хуульд нийцүүлэн хяналт тавьж, тогтоол тус бүрт хувийн хэрэг хөтлөн ажиллаж байна. Мөн үнийн өсөлт, цаг үеийн нөхцөл байдлын шаардлагаар “Агро үйлчилгээний техникийн үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай” болон “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит III хуралдаанаар батлаад хэрэгжүүлж байна.	100
2.3	ИТХ-ын Ажлын албаны дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсэг болон тооллогын комисс байгуулан ажиллуулах, хяналт тавих	-	Ажлын хэсгийн тоогоор	Сумын ИТХ-ын Ажлын албаны дотоод хяналт шалгалт хийх журам, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу шалгалт, тооллогууд хийгдсэн.	Тайлант хугацаанд байгууллагаас дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг болон тооллогын комисс ажилласан байх	Сумын ИТХ-ын Ажлын албаны дотоод хяналт шалгалт хийх журмыг боловсруулан Хурлын даргын 2023 оны 49 дүгээр захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Магадлан итгэмжлэлийн аудитын багтай хамтран чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлсэн хяналтыг хийлээ. Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/94 дүгээр захирамжаар төрийн болон орон нутгийн өмчийг бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим	100

						системд нэвтрүүлэх үүрэг бүх төрийн байгууллагуудад өгөгдсөний дагуу мэдээллийн баазыг шинэчлэх бэлтгэл ажлыг хангах, эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг томилон ажиллууллаа. Мөн Хурлын ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/13 тоот тушаалаар оны эцсийн үндсэн хөрөнгийн тооллогийн комиссыг байгуулан тооллого хийлгүүлэн мэдээ тайланг аймгийн Өмчийн газарт илгээлээ.	
2.4	Байгууллагын үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь хэмжээгээр	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө маш сайн үнэлэгдсэн.	Байгууллагын 2025 оын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилт 85 хувиас дээш үнэлэгдсэн байна.	Сумын ИТХ-ын байгууллагын Ажлын албаны 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Хурлын дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулаад, батлан хэрэгжүүллээ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн гүйцэтгэл хувьтай үнэлэгдсэн.	90
Стратеги зорилго 3: Сумын ИТХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эргэх холбоог бий болгох.							
3	Зорилт 3: Ил тод нээлттэй байдлыг хангах олон нийтийн оролцоог хангах						
3.1	Сумын ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлэн батлах бодлогын чанартай нийтэд хандсан асуудлыг багийн иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, иргэдийг өргөнөөр оролцуулах	Батлагдсан төсөв	хэлэлцүүлгийн тоогоор	Жаргалант сумын 2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэлсэн жагсаалтыг 3 багийн	ИТХ-аас гарах бодлогын чанартай асуудлуудыг тухай бүр иргэд болон холбогдох хүмүүсийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулна.	2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Жаргалант баг, 06 дугаар сарын 10-ны өдөр Дулаан-Уул баг, 06 дугаар сарын 12-ны өдөр Улаантолгой багийн иргэдийн Нийтийн Хуралдааныг зохион байгуулж иргэдээсээ санал авч “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө”-өөр 2026 онд хийгдэх эрэмбэлсэн саналын жагсаалтыг гаргасан ба сумын хэмжээнд 100 ажил эрэмблэгдсэн ба энэ жагсаалтыг аймгийн ЗДТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн. Энэхүү 2026 онд хийгдэх эрэмблэгдсэн	100

				иргэдээс саналыг авч хэлэлцүүлэн баталсан.		ажлын жагсаалтыг “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 3.2.1 дэх заалтын дагуу сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны 02/33 дугаар тогтоолоор баталсан.	
3.2	ИТХ-ын төлөөлөгч нарыг хууль тогтоомж, дүрэм журам, бусад шаардлагатай мэдээ, мэдээллээр тогтмол хангах	Батлагдсан төсөв	Төлөөлөгч нарын ажиллах журмын хэрэгжилт сайжирна.	ИТХ-ын төлөөлөгчдөд гарсан тогтоол шийдвэрийг хүргүүлсэн.	Төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж, мэдээ мэдээллээр хангаж арга зүйн зөвлөгөө өгөх, хийсэн ажлын талаар мэдээллийн хуудсанд байршуулна.	Шинээр сонгогдсон 9 дэх бүрэн эрхийн төлөөлөгчдийг шинэчлэгдсэн ЗЗНДНТУТХууль бүхий гарын авлага, тэмдэглэлийн дэвтэрээр хангалаа. ИТХ-ын төлөөлөгчид болон багийн иргэдийн Нийтийн Хурлын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2 удаагийн, мөн төлөөлөгчийн ёс зүйн асуудлаар 1 сургалт зохион байгуулсан. Төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж, мэдээ мэдээллээр хангаж, хууль эрх зүй болон арга зүйн зөвлөгөө өгч байна.	90
3.3	Сумын ИТХ-ын хурлаас гаргасан бодлого, тогтоол шийдвэр, үйл ажиллагаа болон Төлөөлөгч, Хороодын ажлыг иргэд олон нийтэд мэдээлэх, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээлэл, цахим орчноор нийтэд түгээх, сурталчлах, байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэх, баяжилтыг тогтмол хийх	Батлагдсан төсөв	Хурлаас гаргасан бодлого, тогтоол шийдвэр мэдээлсэн тоогоор, Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл шуурхай хүрэх, ил тод байдал хангагдах	Сумын ИТХ-ын 2024 онд шийдвэрлэсэн асуудлууд, гаргасан тогтоол шийдвэрүүд олон нийтэд шуурхай мэдээлэгдсэн. Цахим орчинд болон мэдээллийн самбарт мэдээллийг тогтмол байршуулдаг.	2025 онд хуралдан шийдвэрлэсэн асуудлууд болон гаргасан тогтоол шийдвэрүүд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал сүлжээ, цахим болон бусад хэлбэрээр ил тод олон нийтэд мэдээлэгдсэн, сурталчилагдсан байх. Баяжилт	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай мэдээлэх, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор сумын ИТХ-аас батлагдан гарсан тогтоол шийдвэрүүд, ИТХ-ын үйл ажиллагаа, болон Төлөөлөгч, Хороодын ажлыг, цаг үеийн мэдээ мэдээллийг мэдээллүүдийг өөрийн албан ёсны цахим хуудас болох http://jargalant.orkhon.khural.mn/ болон “Улсын тэргүүний Жаргалант сум”, “Жаргалантынхан” болон ИТХ-ын ажлын албаны цахим хуудас, Багуудын цахим хуудсанд цаг тухай бүрт байршуулж байна. Мөн мэдээллийн самбарт	100

					байнга хийгдсэн байх.	мэдээлэл баяжилтыг тогтмол хийж байна. Энэхүү үйл ажиллагааг эрчимжүүлэх, ИТХ-ын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэдэд мэдээ мэдээллийг тогтмол, шуурхай хүргэхийн тулд 2025 оны төсөвт суулган 01 дүгээр сараас ИТХ-ын ажлын албанд Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтны орон тоог шинээр бий болгон ажиллуулж байна. Иргэд сонгогчдод мэдээлэл хүргэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Жаргалант сумаас аймгийн ИТХ болон сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчид, аймгийн төрийн байгууллагууд оролцсон “Иргэдийн оролцоо, төлөөлөгчийн манлайлал, төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөгийг аймгийн ИТХ-тай хамтран сумандаа 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай зохион байгууллаа.	
Стратеги зорилго 4: Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг хангах							
4	Зорилт 4: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах						
4.1	Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-аас дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэр, үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллах.	-	Хэрэгжилтийн хувь хэмжээгээр	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалттай биелсэн.	Дээд газраас баталсан тогтоол, шийдвэр, үүрэг даалгаврыг хяналтад авч бүрэн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-аас дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэр, үүрэг чиглэлийг ирүүлсэн албан бичиг, удирдамж, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. УИХ-ын Тамгын газраас ирүүлсэн ТГ-04/1310 албан бичгийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдөр шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах XIV дүгээр удаагийн тэмцээний хүрээнд Жаргалант сумын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.	80

4.2	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Батлагдсан төсөв	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, гэмт хэрэг буурсан байна.	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг байгууллага, зөвлөлийн гишүүдээс саналыг авч нэгтгэн Зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөснөөс 42 арга хэмжээ 77,7 хувьтай биелэгдсэн.	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, иргэний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөг 80-аас доошгүй хувийн хэрэгжилттэй дүгнүүлж ажилласан байна.	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг байгууллага, зөвлөлийн гишүүдээс саналыг авч нэгтгэн Зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж 4 бүлэг 36 ажлыг гүйцэтгэхээр батлан хэрэгжүүлж төлөвлөснөөс 35 арга хэмжээг зохион байгуулж 97,2 хувийн биелэлттэй хэрэгжлээ. Зөвлөл сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн ухамсар, соёлыг төлөвшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг тогтоон арилгах, галын аюулгүй байдал зэрэг чиглэлээр зохих хууль хяналтын болон бусад чиг үүргийн байгууллагуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлж, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж, чиглэл өгөн, хяналт тавьж ажиллаж байна. Жаргалант сумын ИТХ дарга бөгөөд Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлийн дарга Ш.Билгүүнбаатарын урилгаар 2025 оны 11 сарын 28-ны өдөр Булган аймгийн Хангал сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга М.Цэцэгмаа, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга Н.Эрдэнэцогт нар “Хамтран ажиллах санамж бичиг”-т гарын үсэг зурж. Санамж бичгийн хүрээнд хөрш сумдууд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хамтын ажиллагааг сайжруулах, мэдээлэл солилцох, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахаар тохиролцлоо.	90
-----	---	------------------	--	---	---	---	----

4.3	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах	Батлагдсан төсөв	Шилэн дансны хуулийн хэрэгжилтээр	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим сайтад мэдээллийг хугацаанд байршуулсан.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж цахим сайтад мэдээллийг хугацаанд байршуулна.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж цахим сайтад мэдээллийг хугацаанд нь байршуулж байна. Ажлын албаны даргаас хэрэгжилтэд байнга хяналт тавьж байна.	90
4.4	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Батлагдсан төсөв	Сумын ИТХ-ын Төлөөлөгч, төрийн захиргааны албан хаагчдын ХАСХОМ-ийг хугацаанд нь авч нэгтгэж тайланг хүргүүлсэн байна. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын ХАСХОМ-ийг 2024 онд хугацаанд нь авч нэгтгэн хөдөлгөөний	-Сумын ИТХ-ын Төлөөлөгч, УТ-ын, төрийн захиргааны албан хаагчдын ХАСХОМ-ийг хугацаанд нь авч нэгтгэх, хөдөлгөөний бүртгэлүүдийг тогтмол хийх, тайланг хугацаанд 3 сарын 01-ний дотор хүргүүлэх, ИТХ-ын төлөөлөгчид, Сумын Засаг дарга, орлогч, 3 багийн Засаг дарга нарыг гарын авлага, мэдээллээр ханган ажилласан байх.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын 2024 оны ХАСХОМ-ийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор хугацаанд нь авч нэгтгэж, хөдөлгөөний бүртгэлүүдийг тогтмол хийж, тайланг хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн. 2025 онд шинээр үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон 1 хүний мэдүүлгийг хугацаанд нь мэдүүллээ. Мөн ИТХ-ын 21 төлөөлөгч, багийн Засаг дарга нарт сургалт хийн , гарын авлага мэдээллээр ханган ажиллаж байна.	100

				бүртгэлүүдийг тогтмол хийж, тайланг хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн.			
4.5	Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах	Батлагдсан төсөв	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна	Жендэрийн судалгаа тайлан мэдээг хугацаанд хүргүүлэн ажилласан.	Байгууллагын ажилтан албан хаагчдаас Жендэрийн асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч судлан, холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлнэ . Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, албан хаагчдад хууль тогтоомжоор сургалт зохион байгуулна. Жилийн эцэст судалгаа, тайланг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байх.	Хурлын ажлын албаны албан хаагчдаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар Жендэрийн асуудлаар өргөдөл, гомдол гаргаагүй ба Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах заалтын дагуу Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны даргын тушаалаар баталсан маягтын дагуу Жендэрийн судалгаа тайлан мэдээг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	90
4.6	Төрийн болон албан нууцын тухай хуулийн	Батлагдсан төсөв	Хуулийн хэрэгжилт	Байгууллагын нууцын хуулийн	Байгууллагын нууцын хуулийн хэрэгжилтийг	Төрийн болон албан нууцын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90

	хэрэгжилтийг ханган ажиллах		хангагдсан байна	хэрэгжилтийг хангаж, албан хаагчдад хууль тогтоомжоор сургалт зохион байгуулж, судалгаа, тайланг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.	хангаж, албан хаагчдад хууль тогтоомжоор сургалт зохион байгуулна. -Жилийн эцэст судалгаа, тайланг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байх.	Тагнуулын Ерөнхий газрын Орхон аймгийн салбараас зохион байгуулсан нууцын сургалтад хамрагдсан. Тагнуулын Ерөнхий газрын Орхон аймгийн салбараас ирүүлсэн албан тоотын дагуу төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг маягтын дагуу 6 дугаар сард хүргүүлээ. Хурлын ажлын албаны албан хаагчдад Төрийн болон албан нууцын тухай хуулийн сургалтыг 11 дүгээр сард хийлээ.	
Стратеги зорилго 5: Сумын ИТХ-ын Ажлын албыг бэхжүүлж, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанарыг сайжруулах.							
5	Зорилт 5: Ажлын албаны хэвийн үйл ажиллагааг хангах						
5.1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хянуулаад батлах, хэрэгжилтийг ханган, үнэлүүлэх	Батлагдсан төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	2024 оны байгууллагын жилийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь батлуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг маш сайн үнэлүүлсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж төлөвлөгөөний хэрэгжилт 85%-аас доошгүй үнэлэгдсэн байх.	Сумын ИТХ-ын Ажлын албаны байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан ИТХ-ын даргаар хянуулаад батлан хэрэгжилтийг ханган ажиллаж 94.3%, маш сайн үнэлүүлээ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хянуулаад баталсан ба хуулийн хугацаанд гүйцэтгэлийн хэрэгжилтийг хянуулаад хувиар буюу үнэлүүлээ.	90
5.2	Төрийн албан хаагчдын сургалтын 2025 оны төлөвлөгөөг боловсруулан	Батлагдсан төсөв	Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээр	Жаргалант сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдын 2024 оны	2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг	Сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллаа.	90

	баталж хэрэгжилтийг хангах			боловсруулан батлуулж хэрэгжүүлсэн.	ханган ажилласан байх.		
5.3	Сумын ИТХ-ын ажлын албаны ажилтнуудын хувийн хэргийн баяжилтыг хийх	-	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын хувийн хэргийг журмын хэрэгжилт хангагдана.	Сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу хөтлөж, баяжилтыг хийсэн.	Сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу хөтлөж, баяжилтыг хийнэ.	Сумын ИТХ-ын байгууллагын 5 албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу хөтөлж, баяжилтыг тухай бүр хийж байна.	100
5.4	Сумын ИТХ-ын төрийн албан хаагч нарын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны нэгдсэн санд бүртгэх	-	Аймгийн ИТХ-ын төрийн албан хаагч нарын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны нэгдсэн санд бүртгэнэ.	Төрийн албан хаагчийн нэгдсэн санд цалин, зэрэг, дэв, шатлалын өөрчлөлтүүдийг тухай бүрт нь оруулсан. Сумын ИТХ-ын төрийн албан хаагч нарын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны нэгдсэн санд хугацаанд бүртгэж нэмэлт	Сумын ИТХ-ын төрийн албан хаагч нарын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны нэгдсэн санд хугацаанд нь бүртгэж, нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийх.	Сумын ИТХ-ын Ажлын албаны төрийн албан хаагч нарын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны нэгдсэн санд хугацаанд нь бүртгүүлж нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хийсэн. 2025 оны 01 дүгээр сараас ИТХ-ын ажлын албанд Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтан шинээр орсон ба бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж байна.	90

				өөрчлөлтийг хийсэн.			
5.5	Хүний нөөцийн мэдээ, тайланг холбогдох газарт хүргүүлэх	-	Тайлан мэдээний үзүүлэлтээр	Тайлан мэдээг хугацаанд хүргүүлж байсан.	Хүний нөөцтэй холбоотой судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Хүний нөөцийн мэдээ, тайланг шаардсан хугацаанд нь аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлж байна. Мөн "Хүний нөөцийн удирдлагын менежментийн систем"-д тухай бүр шинэчлэлтийг оруулж байна.	100
5.6	Сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан баталж, биелэлтийг тооцох	Батлагдсан төсөв	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	Ажлын албаны Төрийн албан хаагчдаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан баталсан ба хагас бүтэн жилээр гүйцэтгэлийн биелэлтийг гаргуулан дүгнэж үр дүнгийн урамшуулал олгосон.	Төрийн албан хаагчид 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулж, хагас бүтэн жилээр гүйцэтгэлийн тайлан гаргаж дүгнүүлсэн байх.	Ажлын албаны төрийн албан хаагчдаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан баталсан ба хагас жилээр гүйцэтгэлийн биелэлтийг гаргуулан дүгнэж үр дүнгийн урамшуулал олголоо. 2025 оны жилийн эцсийн биелэлтүүдийг гаргуулан хянуулж ажлын албаны даргын тушаал гарган 3, 4 дүгээр улирлын урамшууллыг цалингийн сандаа багтаан олголоо.	100
5.7	Сумын ИТХ-ын байгууллагын 2026 оны төсвийн төслийг хянан хугацаанд нь хүргүүлэх	-	Хуулийн хугацаанд хийж хүргүүлсэн эсэх	2025 оны төсвийн төслийг бодитой төлөвлөж батлуулсан.	Сумын ИТХ-ын 2026 оны төсвийн төслийг хийж хугацаанд нь хүргүүлсэн байна.	Сумын ИТХ-ын байгууллагын 2026 оны төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаанд сумын ЗДТГ-ын санхүү албанд хүлээлгэн өгсөн.	100
5.8	ИТХ-ын төсөв, санхүүгийн тайлан гарган хүргүүлэх	-	Хууль, журамд нийцүүлэн үйл	Сумын ИТХ-ын ажлын алба 2024 оны жилийн	Хууль, журмын дагуу гүйцэтгэж, ямар нэг өр авлагагүй,	Хууль журмын дагуу хугацаанд нь ИТХ-ын төсөв, санхүүгийн тайланг хагас болон бүтэн жилээр гарган хүргүүлж, хяналт тавьж байна.	90

			ажиллагааг аа явуулсан байна.	эцсийн тайланг хүргүүлсэн.	санхүүгийн зөрчилгүй үйл ажиллагааг хөтлөн явуулж тайланг хугацаанд нь хүргүүлсэн байх.		
5.9	Баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг мөрдөж ажиллах	-	Хуулийн хэрэгжилт хангагдана.	ХХНЖ-ын дагуу баримтыг хүлээн авсан.	ХХНЖ-ыг мөрдөж ажилласан байх	Архивийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тушаалаар батлагдсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын дагуу ИТХ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/04 захирамжаар “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг баталсан ба Хурлын ажлын албаны БНШК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын шинэчлэн батлаад хууль журмын дагуу мөрдөн ажиллаж байна.	100
5.10	Өмнөх оны баримтуудыг үдэж хадгаламжийн нэгж болгон зааврын дагуу архивт хүлээн авах	-	Архивын заавар журмын дагуу хадгаламжийн нэгж үүсч журмын хэрэгжилт хангагдана.	Ажлын албаны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд 18 нэгж баримтыг хадгаламжийн нэгж болгон хадгалсан.	2025 оны баримтуудыг хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан хүлээн авч данс бүртгэлд бүртгэсэн байх.	2005-2024 оны архивд хадгалагдаж байгаа хадгаламжийн нэгжүүдэд нягтлан шалгалт хийж хадгаламжийн нэгжийг үүсгэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 250 хадгаламжийн нэгжийг үүсгэж архивлаад байсан бол 12 дугаар сарын 10-ны байдлаар нийт 280 хадгаламжийн нэгжийг үүсгэн архивласан.	90
5.11	Архивын баримтыг стандартын дагуу хадгалах, ашиглуулах, бүртгэл хөтлөх	-	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартыг	Архивын баримтуудыг ангилан төрөлжүүлж, бүртгэлжүүлэн, данс	Архивын баримтуудыг стандартын дагуу хадгалан бүртгэл хөтөлнө.	2025 онд байгууллагын байранд засвар хийн өргөжүүлж тусдаа архивийн хадгаламжийн өрөөтэй болсноор сумын архиваас хурлын байгууллагын архивын баримтын шүүгээг авч байгууллагын архивт хийлээ. Хөтлөх нэрийн жагсаалтын	90

			чанд мөрдөнө.	бүртгэлтэй тулгалт хийж байгууллагын архивт хүлээн авсан.		дагуу баримтуудыг ангилан бүртгэлжүүлж нэгж үүсгэн хадгалж байна.	
5.12	Сумын ажлын албаны ИТХ-ын техник тоног төхөөрөмж, дотоод сүлжээ болон интернетийн хэвийн үйл ажиллагааг хангах	Батлагдсан төсөв	Ажилчдын ажиллах орчин бүрдэнэ.	Албан хаагчдын интернет сүлжээг сайжруулж, шаардлага хангаж ажилласан. албаны мэргэжилтэн болон нярав шинэ ширээ сандал, мэргэжилтэн шинэ ширээний болон зөөврийн компьютер, олон үйлдэлт өнгөт принтерээр хангагдсан. Мөн албаны хэрэгцээнд 1 шинэ зөөврийн компьютер худалдан авсан.	Албан хаагчид хэвийн ажиллах нөхцөлөөр хангагдсан байх.	Сумын ИТХ-ын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажиллагсадын ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ажлын эрүүл, аюулгүй нөхцөл, тоног төхөөрөмжөөр хангах заалтын дагуу дотоод болон интернэтийн сүлжээг шинэчлэх, засвар үйлчилгээ хийхэд шаардагдах хөрөнгийг гарган шинэчлэн засварласан. Сумын ЗДТГ-ын интернэтийн сүлжээг хамтран ашигладаг байсан нь тасалдах, гацах, зарим албан хаагчдын санамсаргүй үйлдээс болж ажиллахгүй тохиолдлууд гардаг байсан тул 2025 онд Мобинеттэй гэрээ байгуулан тусдаа аюулгүй, хурдтай интернэтийн сүлжээтэй болсон. 2025 онд шинээр ажилд орсон Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтныг шинэ зөөврийн компьютерээр хангалаа.	100
5.13	Компьютер, тоног төхөөрөмжинд вирусны хамгаалалтыг тухай	Батлагдсан төсөв	Албан хаагчид болон төлөөлөгч	Албан хаагчдын компьютерт Kaspersky	Албан хаагчид нотебүүк, компьютер, тоног	Хурлын ажлын албаны техник хэрэгсэл хуучирч шаардлага хангахгүй болсонтой холбогдуулан 2024 онд шинээр одоо цагт ашиглаж буй программ хангамжид таарах	100

	бүр шинээр суулгуулах, засвар үйлчилгээ хийлгэх шаардлагатай тоног төхөөрөмжийг засварлах		нарын хэвийн ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.	вирусны хамгаалалтыг суулгасан.	төхөөрөмжүүд хэвийн ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.	РС, техник хэрэгсэл худалдан авсан. 2025 оны 12 дугаар сард ажлын албаны компьютеруудын вирусны хамгаалалтын программын (Кашперски) хугацаа дууссан тул аймгийн ЗДТГ-ын Мэдээллийн технологийн албаар дамжуулан төлбөрийг 2026 оны эхээр төлөхөөр вирусны хамгаалалтын программ албан ёсоор худалдан авч албаны компьютер, тоног төхөөрөмжинд суулгуулсан.	
5.14	Сумын ИТХ-ын хөрөнгийн хөдөлгөөний тайлан мэдээг гаргах, эд хөрөнгийн тооллого хийх	Батлагдсан төсөв	Эд хөрөнгийн тооллого хийсэн байна.	Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж хөдөлгөөний тайлан мэдээг хугацаанд хүргүүлсэн.	Байгууллагын тооллогыг комисс хугацаанд тооллого хийж мэдээ тайланг холбогдох газар хүргүүлсэн байх.	ҮСХ-ны даргын 2020 оны А/33 дугаар тушаалаар батлагдсан маягт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам”-ын дагуу тушаал гарган 2025 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг явуулан тайлан мэдээг хүргүүлсэн. ИТХ-ын байгууллага дээр данстай 1997оноос хойш ашиглаж байсан цаашид ашиглах боломжгүй болсон 5,7 сая төгрөгийн үнэлгээтэй 36ш тавилга, эд хогшил, 2007 оноос хойшхи 31,9 сая төгрөгийн үнэлгээтэй 28ш компьютер, тоног төхөөрөмжийг актлуулахаар аймгийн Засаг даргад хүсэлт илгээгээд хүлээгдэж байна. Оны сүүл 12 дугаар сард аймгийн Өмчийн газрын албаны хүмүүс ирж жагсаалттай тулган баримтжуулаад явсан.	90
5.15	Сумын ИТХ-ын шагналаар шагнуулах хүмүүсийн материалыг хүлээн авч удирдлагад танилцуулан шийдвэр гаргах	Батлагдсан төсөв	Журмын шаардлага хангагдсан байна. Шагнагдсан иргэдийн тоо	ИТХ-ын даргын захирамжаар 2024 онд 6 байгууллага, 3 багийн 33 иргэнийг ИТХ-ын “Хүндэт	Журмын шаардлага хангасан материалыг хүлээн авч бүртгэн ИТХ-ын даргын захирамжаар	Сумын ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”, “Өргөмжлөл”-өөр шагнуулах хүмүүсийн материалыг хүлээн авч журмын шаардлага хангасан материалыг нягтлан шалгаж ИТХ-ын даргын захирамжаар 2025 оны жилийн эцсийн байдлаар 4 байгууллага, 3 багийн 14 иргэнийг ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”,	100

				жуух бичиг”, мөнгөн шагналаар шагнасан.	иргэдийг шагнаана.	2 иргэнийг “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнасан.	
5.16	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг авч хугацаанд нь шийдвэрлэж хариу өгөх	-	Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо шийдвэрлэлтийн хувь	Сумын ИТХ-д 2024 онд нийт 11 өргөдөл, санал хүсэлт ирснийг шийдвэрлэсэн.	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэнэ. Өргөдөл гомдлын мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргэнэ.	2025 оны жилийн эцсийн байдлаар ИТХ-ын байгууллагад нийт 18 дэмжлэг, тусламж хүссэн өргөдөл, хүсэлт ирсэнийг хуулийн хугацаанд шийдвэрлэн Хурлын байгууллагын дотоод журмын дагуу дэмжлэг, буцалтгүй тусламж олгосон ба холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлсэн.	100
5.17	Төлөөлөгчид болон ИНХ-ын Зөвлөлийн гишүүдэд холбогдох сургалтыг үе шаттай зохион байгуулж хамруулах	Батлагдсан төсөв	Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид, ИНХ-ын зөвлөлийн гишүүдийн мэдлэг чадвар дээшилнэ.	2024 оны ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын даргалагч нар болон зөвлөлийн гишүүдэд 3 удаагийн сургалт зохион байгуулсан.	Сургалтыг хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг нь хангаж ажиллана. Тухай бүрт нь сургалтын удирдамж батлуулан сургалтыг зохион байгуулна.	Сумын ИТХ-ын 9 дэх бүрэн эрхийн шинээр сонгогдсон Төлөөлөгчдөд Монгол улсын ЗЗНДНТУТ хуулийн шинэчилсэн найруулга, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага, баримт бичгийн стандартын тухай болон ОНХС-гийн үйл ажиллагааны журмын талаар сургалт зохион байгуулсан. Мөн аймгаас зохион байгуулсан аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгч нарт зориулсан сургалт болон Төсвийн хяналтыг сургалтад сумын ИТХ-ын төлөөлөгчдийг хамруулсан.	80
5.18	Бусад аймаг, сумдын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах	Батлагдсан төсөв	Хамтын ажиллагаа сайжирч, сайн туршлагаа солилцоно		Аймаг сумдуудад туршлага судлах тусгай удирдамжийн дагуу ажлын албаны ажилтнууд туршлага судлана.	2025 онд ИТХ-ын дарга болон Дулаан-Уул, Улаантолгой багуудаас сонгогдсон төлөөлөгчид, сумын холбогдох албаны мэргэжилтнүүдийн хамтаар Булган аймгийн Хишиг-Өндөр суманд Франц улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Эко хог хаягдал боловсруулах төсөлтэй танилцлаа. Хөрш зэргэлдээ Булган аймгийн Хангал, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумдын ИТХ-ын дарга	100

						тэргүүтэй албаны төлөөлөгчид 2025 оны 11 сард манай суманд ажлын айлчлал хийж туршлага солилцлоо. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хүрээнд 3 сум хамтран ажиллах “Санамж бичиг” үзэглэлээ.	
Стратеги зорилго 6: ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх.							
6	Зорилт 6: Багийн ИНХ-ын хэвийн үйл ажиллагааг хангах						
6.1	Багийн ИНХ-д зөвлөн туслах арга зүйн зөвлөгөө өгөх	Батлагдсан төсөв	ИНХ-ын үйл ажиллагаа тогтмолжин о.	БИНХ хариуцсан мэргэжилтэнтэй болсон.	Цаашид арга зүйн зөвлөгөөгөөр ханган хамтран ажиллана.	Багийн ИНХ-ын дарга болон Зөвлөлийн гишүүдэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд шинэчлэсэн заалтууд орсон дагуу уг хуульд тусгагдсан багийн ИНХ-ын үйл ажиллагаатай холбоотой заалтуудын талаар гарын авлага бэлтгэн тараав. 3 багийн ИНХ нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус бүр 1 хуралдаж тогтоолууд гаргасан. Тус хуралдаануудын үйл ажиллагаанд холбогдох хууль болон арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.	80
6.2	Багийн ИНХ-ын үйл ажиллагааны тайланг тогтмол авч байх, мэргэжил арга зүйгээр хангах		Хамтын ажиллагаа сайжирна.	Багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны тэмдэглэлийг дэгт заасан хугацаанд албажуулж, иргэдээс ирсэн санал хүсэлтийг нэгтгэн иргэдийн Нийтийн	Тайланг авч хэвшинэ. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөнөөр Багийн ИНХ-ын үйл ажиллагаа сайжирна.	Сумын 3 багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны тэмдэглэлийг дэгт заасан хугацаанд албажуулж, иргэдээс ирсэн санал хүсэлтийг нэгтгэн иргэдийн Нийтийн Хурлын тогтоолын хамт албажуулсан. БИНХ-ын тогтоол, тэмдэглэл, ирц болон тайлан мэдээг тухай бүр багийн ажлын алба болон БИНХ-ын дарга нараас гаргуулан авч мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол ханган хамтран ажиллаж байна.	90

				Хурлын тогтоолын хамт албажуулж байна. Тайланг хугацаанд нь авч байна.				
	Нийт үнэлгээ							94,8

Биелэлт хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч

ИТХ-ын дарга /Ш.Билгүүнбаатар/
(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг 2025.01.06

Биелэлт тайлагнасан: Төсвийн Шууд захирагч

ИТХ-ын Нарийн бичгийн дарга /Ц.Ганбаяр/
(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг 2025.01.05